



УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жуковын АЛДАРЖАВХЛАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-23-46, Факс: 32-70-16
E-mail: aldarjavkhan@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.05.02 № УИХ-03/5528
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Ж.АЛДАРЖАВХЛАН

0000000138



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жуковын АЛДАРЖАВХЛАН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-23-46, Факс: 32-70-16
E-mail: aldarjavkhan@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.04.16 № 442-03/4649
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

“Монгол Улсын Их Хурлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, “Хууль тогтоомжийн тухай” хуулийн 5 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1.8-т заасны дагуу “Хот байгуулалтын тухай хууль” /шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулахаар хуулийн төслийг санаачлан боловсруулж Монгол Улсын Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн саналыг авч Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр баримт, бүрдүүлбэрийг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, Засгийн газрын санал болон холбогдох материалыг хавсаргав.

Хавсралт 25 хуудастай

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ж.АЛДАРЖАВХЛАН

0000000116



Г УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.АЛДАРЖАВХЛАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025. 01. 07 № ХХ 153
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000255000343

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 47 дугаар тэмдэглэлд:

"4.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн санаачлан боловсруулсан Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн санаачлан боловсруулсан Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хуулийн төслийн 3 дугаар зүйлд "Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө." гэж, мөн хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлд "Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө." гэж тус тус тусгасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно." гэснийг, мөн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад "Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт хориг тавих"-аар заасан Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийг, мөн хуулийн Тавьдугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй." гэснийг зөрчсөн агуулгатай байх тул тус хуулийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр, эсхүл шаардлагатай тохиолдолд дагаж мөрдөх хугацааг тодорхой тусгах нь зүйтэй.

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор хуулийг батлагдсан өдрөөс дагаж мөрдөхөөр заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтуудыг зөрчсөн гэж шийдвэрлэснийг дурдах нь зүйтэй.

2.Хуулийн төслийн үзэл баримтлалын үндэслэл, шаардлагад Хот байгуулалтын тухай хуультай холбоотой зохицуулалтын хүрээнд нийт 56 давхардал, хийдэл, зөрчил байгааг дурдсан боловч уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаарх мэдээлэл болон түүнтэй холбоотой зохицуулалт хуулийн төсөлд тодорхойгүй байна.

Мөн хуулийн төслийн үзэл баримтлалд хот байгуулах үйл ажиллагаанд оролцогч, хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, хот байгуулалтын мэргэжлийн байгууллагын чиг үүргийг тодорхой болгон сайжруулах, хот, суурин газрын төлөвлөлт, хэрэгжилтийг хангахтай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж хоорондын харилцан уялдааг хангах зэрэг зорилтыг тусгасан боловч хуулийн

төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй, түүнчлэн, төрийн өмчит сургуулийг төлөвлөхдөө жишиг болгосон хүн ам, өрхийн тоог хэрхэн тооцсон зэрэг нь тодорхойгүй байна. Тодруулбал, тус хуулийн төсөл батлагдсанаар хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан дээрх асуудлууд хэрхэн шийдвэрлэгдэх нь ойлгомжгүй байна.

Иймд, Хууль тогтоомжийн тухай хуулийн 16.1-д заасны дагуу хуулийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулах нь зүйтэйг анхаарах.

3.Хот байгуулалтын тухай хуулийн 12.1-д “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгалийн нөхцөл, нөөц, экологийн тэнцвэрт байдал, хот байгуулалтын сөрөг үр дагаварт иж бүрэн үнэлгээ өгсний үндсэн дээр хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн үндсэн сүлжээний үйлчлэлийн зохистой хүрээнд тулгуурласан бүс нутгийн оновчтой бүтэц, хот, тосгоны тогтолцоог бүрдүүлэх шаардлагыг хангасан байна.” гэж заасан.

Харин хуулийн төслийн 2 дугаар зүйлд Хот байгуулалтын тухай хуулийн 8.1.1, 9.1.4 дэх заалтуудад “энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.5, 12.6-д заасан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний шаардлагад нийцүүлэн” гэсэн нэмэлт оруулахаар тусгасан нь Хот байгуулалтын тухай хуулийн дээрх хэсэгтэй агуулгын хувьд давхардахаар байх тул дахин нягтлах.

4.Хот байгуулалтын тухай хуулийн 12.6-д “Хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь тухайн хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу боловсруулсан зураг төслийг хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийг тооцож, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тодорхойлсон байх бөгөөд холбогдох норм ба дүрэм, журамд заасны дагуу дараахь асуудлыг тооцон төлөвлөнө.” гэж заасан.

Харин хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Хот байгуулалтын тухай хуулийн 12.6 дахь хэсэгт “12.6.4.1000 хүртэл хүн ам, эсхүл 250 хүртэлх өрх тутамд 100 хүүхдийн багтаамжтай нэгээс доошгүй цэцэрлэг болон 200 хүүхдийн багтаамжтай нэгээс доошгүй төрийн өмчийн сургуулийг төлөвлөж тооцох.” гэж нэмэхээр тусгаснаас дүгнэхэд улсын төсвөөс эдгээр сургууль, цэцэрлэгийг барьж байгуулах, үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулахад шаардагдах хүний нөөц, хөрөнгө оруулалт, төсөв санхүүгийн зардал гарахаар байна. Гэтэл хуулийн төслийн зардлын тооцооны судалгаанд уг хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нэмэлт зардал шаардахгүй гэж дүгнэсэн нь үндэслэлгүй юм.

Иймд хуулийн төслийн холбогдох судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу дахин боловсруулах нь зүйтэй байна.

5.Хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “...14.2 дахь хэсгийн “хуулийн” гэсний дараа “12 дугаар зүйлийн 12.4, 12.5, 12.6-д заасан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний шаардлагын” гэж нэмэх”-ээр тусгажээ.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14.2-т заасан “хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, батлуулах”-тай холбоотой

зохицуулалт нь Хот байгуулалтын тухай хуулийн 12.4, 12.6-д заасан зохицуулалттай хамааралгүй байх тул дээрх зохицуулалтыг нягтлах нь зүйтэй.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

Ж.АЛДАРЖАВХЛАН

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хот байгуулалтын тухай хуулийг анх 1998 онд баталсан бөгөөд хот байгуулалтын салбарын хөгжлийн чиг хандлагад үүссэн цаг үеийн шаардлагаар уг хуулийг 2008 онд шинэчлэн найруулж, нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Энэ хууль хэдийгээр тухайн цаг үеийн хөгжлийн шаардлагыг хангаж байсан боловч өнөөгийн нийгмийн хөгжилд нийцэхгүй, хэрэгцээ, шаардлагыг тэр бүр хангахгүй болжээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан Хот байгуулалтын тухай хуулийг бусад хууль тогтоомж, эрх зүйн акттай уялдуулах ажлын хүрээнд уг хуулийн хийдэл, давхардал, зөрчлийн судалгаа хийгдэж, уг хуультай холбоотой нийт 56 давхардал, хийдэл, зөрчил байна гэсэн дүгнэлт гарсан байна.

Сүүлийн 20 гаруй жил хотжих үйл явц эрчимтэй явагдаж, хөдөөнөөс хот, суурин газрыг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр хотжилтын түвшин хурдацтай нэмэгдэж, улмаар 67.6 хувьд хүрээд байна. Тухайлбал, нийслэл, бүсийн тулгуур төв болон аймгийн төв болох 23 хотод манай улсын нийт хүн амын 60 гаруй хувь нь оршин сууж, ажил, хөдөлмөр, бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа. Үүнээс зөвхөн Улаанбаатар хотод оршин суугчдын тоо 1 сая 800 мянгад хүрч, аж ахуйн нэгж, байгууллагуудын 70 орчим хувь нь байршиж, дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байна. Мөн Дархан, Эрдэнэт, Чойбалсан зэрэг томоохон хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрлийн улмаас дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд зэрэг иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний даац хэтэрч, хүртээмж хүрэлцэхгүй байгаагаас нийгэм, эдийн засгийн олон асуудал тулгамдаад байна.

Иймээс төвлөрлийг сааруулахын тулд орон нутгийн зэрэглэлтэй хот, дагуул хотуудыг дэмжин байгуулах замаар хүн амын тогтвортой хөгжил бүхий нутагшилт, суурьшлын бодлогыг шинээр боловсруулан хэрэгжүүлэх шаардлага бий болсон.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бий болгох, хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлэх зорилго бүхий Улаанбаатар хот-"20 минутын хот" стандарт, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот

хөдөөгийн сэргэлтийн хүрээнд Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, дагуул хот, шинэ суурьшлын бүс байгуулах зорилт тусгагдсаны дагуу Хөшигийн хөндийн шинэ суурьшлын бүс, Орхоны хөндийд хот байгуулах зэрэг ажлуудыг эхлүүлээд байна.

Иймээс хот төлөвлөлт, барилгажилт, газар олголтын талаар гарч байгаа зөрчлийг арилгах, иргэдийг эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хот, суурин газарт хотхоны төлөвлөлтийг хийхдээ эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг оновчтой тооцож төлөвлөхөд чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага үүсэж байна.

Мөн түүнчлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч болон хот төлөвлөлтийг хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, хот байгуулалтын мэргэжлийн байгууллагын үүрэг хариуцлага тодорхой болгох, хот, суурин газрын төлөвлөлт, хэрэгжилтийг хангахтай холбоотой харилцааг зохицуулахаар уг хуулийн төслийг боловсрууллаа.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 3 зүйлтэй бөгөөд хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөлтөд тавигдах тусгай шаардлагад оршин суугчдын тоотой харилцан хамааралтайгаар хүртээмжтэй байдлаар төлөвлөх буюу 250 хүртэлх өрх тутамд нэгээс доошгүй цэцэрлэг, 1000 хүртэлх өрх тутамд нэгээс доошгүй төрийн өмчит сургуулийг төлөвлөж тооцох батлах, түүний хэрэгжилтийг хангаж, тайлагнадаг байх, батлагдсан төлөвлөлтийг зөрчиж барилга барих зөвшөөрөл шинээр олгосон тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох зохицуулалтыг тусгалаа.

Гурав.Хуулийн төслийн батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалтад “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах .. эрхтэй.”, мөн зүйлийн 7 дахь заалтад “сурч боловсрох эрхтэй. ...” гэсэн иргэний үндсэн эрх хангагдана.

Хот байгуулалтын асуудлаар төрөөс баримталж буй бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн таатай орчин бий болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг сайжруулах зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа бөгөөд уг хуулийн төсөлтэй холбогдуулан Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин газрын дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд шинэ суурьшлын бүс байгуулах хот төлөвлөлт хийхдээ иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг хангах, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн хүртээмжтэй, зөв оновчтой тооцож төлөвлөх, түүнд хяналт тавих эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлэх зорилгоор Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтад өөрчлөлт оруулан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулахдаа хуульд заасан шаардлагад зайлшгүй нийцүүлэх зохицуулалтыг тусгаснаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг батлахдаа хуульд заасан шаардлагад нийцсэн эсэхэд хяналт тавьж, батлах эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгоно.

Мөн аймаг, нийслэлийн Засаг дарга батлагдсан төлөвлөгөөг үндэслэн газар олгохдоо түүнд хяналт тавих, мөн газар олголт нь батлагдсан төлөвлөгөөнд нийцсэн эсэх асуудлаар тайлагнах үүргийг хэрэгжүүлэхийг мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтад нэмэлт оруулахаар тусгалаа.

Уг хуулийн төсөл батлагдсанаар хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч болон хот төлөвлөлтийг хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, хот байгуулалтын мэргэжлийн байгууллагын үүрэг хариуцлага тодорхой болно.

Аймаг, нийслэлийн хот, суурин газрын төлөвлөлтөд, суурьшлын бүсийг төлөвлөхдөө нэн тэргүүний ээлжид хүүхдийн суралцах цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг 250 өрх бүрд 1 цэцэрлэг, 1000 өрх бүрд 1 төрийн өмчийн сургууль байхаар тооцдог болно.

Иймд хуулийн төслийг боловсруулахдаа Үндэсний статистикийн хорооноос Улаанбаатар хотын нийт өрх, түүнд ногдох хүүхдийн дундаж үзүүлэлтийн талаарх статистик тоонд мэдээллийг авсан бөгөөд 18 хүртэлх насны хүүхэдтэй 1000 өрхөд ногдох хүүхдийн дундаж тоо нь 2662, харин 6 хүртэлх насны хүүхэдтэй 1000 өрхөд ногдох хүүхдийн тоо 1607 байна. Үндэсний статистикийн хорооноос авсан энэхүү судалгааг дүүрэг тус бүрээр харьцуулан авч үзсэний үндсэн дээр цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг оновчтой төлөвлөх эрх зүйн орчныг тусгалаа.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бий болгох, хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй, нийгмийн болон инженерийн дэд бүтэц бүхий хотууд бий болно.

Улаанбаатар хотод сүүлийн жилүүдэд хот төлөвлөлтийн стандартад нийцэхгүй зөвхөн ашгийн төлөө арилжааны барилгууд ихээр баригдаж тухайн орон сууцанд

амьдарч буй иргэдийн эрх ашиг хөндөгдөж, бага насны хүүхдүүдийн сурах эрх хязгаарлагдаж сургууль, цэцэрлэгийн хүртээмжгүйгээс хол газарт суралцах, хүүхдүүдийг сургууль, цэцэрлэгт зөөвөрлөх асуудал залуу гэр бүлүүдийн хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлөх, мөн хүүхдүүдийн хол газар зорчилт нь автозамын түгжрэлд голлох нөлөөг үзүүлж байгаа асуудал шийдэгдэх нөхцөл бүрдэнэ.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Хот байгуулалтын тухай хуулийг анх 1998 онд баталсан бөгөөд хот байгуулалтын салбарын хөгжлийн чиг хандлагад үүссэн цаг үеийн шаардлагаар уг хуулийг 2008 онд шинэчлэн найруулж, нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд шинэ суурьшлын бүс байгуулах хот төлөвлөлт хийхдээ иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг хангах, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн хүртээмжтэй, зөв оновчтой тооцож төлөвлөх, түүнд хяналт тавих эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлэх зорилгоор Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтад өөрчлөлт оруулан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулахдаа хуульд заасан шаардлагад зайлшгүй нийцүүлэх зохицуулалтыг тусгаснаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг батлахдаа хуульд заасан шаардлагад нийцсэн эсэхэд хяналт тавьж, батлах эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгоно.

Мөн аймаг, нийслэлийн Засаг дарга батлагдсан төлөвлөгөөг үндэслэн газар олгохдоо түүнд хяналт тавих, мөн газар олголт нь батлагдсан төлөвлөгөөнд нийцсэн эсэх асуудлаар тайлагнах үүргийг хэрэгжүүлэхийг мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтад нэмэлт оруулахаар тусгалаа.

Уг хуулийн төсөл батлагдсанаар хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч болон хот төлөвлөлтийг хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, хот байгуулалтын мэргэжлийн байгууллагын үүрэг хариуцлага тодорхой болно.

Аймаг, нийслэлийн хот, суурин газрын төлөвлөлтөд, суурьшлын бүсийг төлөвлөхдөө нэн тэргүүний ээлжид хүүхдийн суралцах цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг 250 өрх бүрд 1 цэцэрлэг, 1000 өрх бүрд 1 төрийн өмчийн сургууль байхаар тооцдог болно.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бий болгох, хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй, нийгмийн болон инженерийн дэд бүтэц бүхий хотууд бий болно.

Улаанбаатар хотод сүүлийн жилүүдэд хот төлөвлөлтийн стандартад нийцэхгүй зөвхөн ашгийн төлөө арилжааны барилгууд ихээр баригдаж тухайн орон сууцанд амьдарч буй иргэдийн эрх ашиг хөндөгдөж, бага насны хүүхдүүдийн сурах эрх хязгаарлагдаж сургууль, цэцэрлэгийн хүртээмжгүйгээс хол газарт суралцах,

хүүхдүүдийг сургууль, цэцэрлэгт зөөвөрлөх асуудал залуу гэр бүлүүдийн хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлөх, мөн хүүхдүүдийн хол газар зорчилт нь автозамын түгжрэлд голлох нөлөөг үзүүлж байгаа асуудал шийдэгдэх нөхцөл бүрдэнэ.

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийн талаар иргэд, олон нийтээс санал авахаар d.parliament.mn цахим хуудсанд байршуулсан, иргэд, олон нийтээс санал ирүүлээгүй болно.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.6.4 дэх заалт нэмсүгэй:

“12.6.4. 250 хүртэлх өрх тутамд нэгээс доошгүй цэцэрлэг, 1000 хүртэлх өрх тутамд нэгээс доошгүй төрийн өмчит сургуулийг төлөвлөж тооцох.”

2 дугаар зүйл. Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт , 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын “төлөвлөгөөг” гэсний дараа “энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.5, 12.6-д заасан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний шаардлагад нийцүүлэн” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын “олгох,” гэсний дараа “хяналт тавих, тайлагнах,” гэж, 12 дугаар зүйлийн 12.4.1 дэх заалтын “тодорхойлсон,” гэсний дараа “эмнэлэг, сургууль, цэцэрлэг түүний хүртээмжийг тооцоолсон,” гэж, мөн зүйлийн 12.5 дахь хэсгийн “байгууламж,” гэсний дараа “эмнэлэг, сургууль, цэцэрлэг түүний хүртээмж,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.3.4 дэх заалт нэмсүгэй:

“27.3.4.Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.5, 12.6-д заасан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд нийцээгүй.”

2 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.1.3.энэ хууль болон Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.5, 12.6-д заасан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний шаардлагад нийцэж байгаа эсэх.”

3 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 12 зүйлийн 12.1.1 дэх заалтын “эрх бүхий байгууллагаас” гэсний өмнө “Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.5, 12.6-д заасан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө болон” гэж нэмсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “Хот байгуулалтын тухай хуулийн” гэсний дараа “12 дугаар зүйлийн 12.4, 12.5, 12.6-д заасан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний шаардлагын” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалтын “төлөвлөгөөг” гэсний дараа “холбогдох хуульд заасан шаардлагад нийцсэн эсэхийг хянаж,” гэж, 30 дугаар зүйлийн 30.1.12 дахь даалтын “хэрэгжүүлэх” гэсний дараа “, тайлагнах” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хууль болон уг хуулийг дагалдан батлагдсан Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд заасан тусгай шаардлагад нийцүүлэн боловсруулж 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө батална.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу баталсан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд заасан тусгай шаардлагад барилгын ажлын зөвшөөрлийг нийцүүлнэ.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу баталсан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд заасан тусгай шаардлагад нийцүүлээгүй барилгын ажлын зөвшөөрлийг хүчингүй болгоно.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал.

Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасны дагуу судалсан болно.

Уг хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшлаагүй болно.

Хоёр. Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан

Нийслэл, бүсийн тулгуур төв болон аймгийн төв болох 23 хотод манай улсын нийт хүн амын 60 гаруй хувь нь оршин сууж, ажил, хөдөлмөр, бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа. Үүнээс зөвхөн Улаанбаатар хотод оршин суугчдын тоо 1 сая 800 мянгад хүрч, аж ахуйн нэгж, байгууллагуудын 70 орчим хувь нь байршиж, дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байна. Мөн Дархан, Эрдэнэт, Чойбалсан зэрэг томоохон хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрлийн улмаас дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд зэрэг иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний даац хэтэрч, хүртээмж хүрэлцэхгүй байгаагаас нийгэм, эдийн засгийн олон асуудал тулгамдаад байна.

Шинэ хот төлөвлөлт хийхэд бүс байгуулах хот төлөвлөлтийг хийхэд иргэдийг эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрахад, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг оновчтой тооцож төлөвлөхөд чиглэсэн эрх зүйн орчныг шинэчлэн бүрдүүлэх, хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч, хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг, хот байгуулалтын мэргэжлийн байгууллагын чиг үүргийг тодорхой болгож сайжруулах, хот, суурин газрын төлөвлөлт, хэрэгжилтийг хангахтай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж хоорондын харилцан уялдааг хангах зорилгоор хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг дагалдан гарах хуулийн төслүүдтэй хамт боловсруулах шаардлагатай байна. Иймд дээрх шаардлагад үндэслэн:

1. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл,
2. Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,
3. Хот суурин газрын дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл,
4. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,
5. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүд нь хот төлөвлөлт, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн хүртээмжтэй холбоотойгоор тулгамдаж буй дээрх асуудлыг шийдвэрлэх, хууль хоорондын нийцлийг хангах зорилгод нийцсэн байна.

Гурав. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал.

Хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулахад хуулиар тавигддаг шаардлагад уг хуулийн зорилгод нийцсэн буюу эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн төлөвлөлт, түүний хүртээмжийг тооцоолж тусгах, уг шаардлагад үндэслэн төлөвлөлтийг батлах, барилгын зөвшөөрөл олгохдоо батлагдсан төлөвлөлтөд нийцсэн эсэхийг хянах, хэрэв төлөвлөлтөд нийцээгүй бол зөвшөөрөл олгохоос татгалзах, эргээд түүнд хяналт тавих, тайлагнах зэрэг тулгамдаж буй үндсэн харилцааг нарийвчлан зохицуулах, хэрэгжилтийг хангах үндсэн зорилгыг хуулийн үзэл баримтлалаар тодорхойлсон бөгөөд Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдан боловсруулсан Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хот, суурин газрын дахин төлөвлөх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд нь хот төлөвлөлт, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн хүртээмжтэй холбоотойгоор тулгамдаж буй дээрх асуудлыг шийдвэрлэх, хууль хоорондын нийцлийг хангах зорилгод нийцсэн байна.

Дөрөв. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж, дараах дүгнэлтийг гаргалаа:

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Зорилгодоо хүрэх бүрэн боломжтой	Нэмэлт зардал шаардагдахгүй

Тав. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариуцлах замаар дүгнэлтийг гаргалаа.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	

	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм		
	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх		Үгүй	
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Шаардлагагүй

3.Эрх агуулагч[8]	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	Шаардлагагүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм		
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)			Шаардлагагүй
4.Үүрэг хүлээгч[9]	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх			Шаардлагагүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		

Хүснэгт 2

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
			Үгүй	

	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	

5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		
